

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ч. Жамба	Дугаар	L319
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Есөнзүйл сум
Төрсөн газар	Есөнзүйл сум	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Есөн зүйлийн сүм	Сүм хийдийн дугаар	ӨХЕЗ 009
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Зүйлийн хурал

Жужа: Яг ямар нэртэй хүрээ байсан юм бэ?

Ч. Жамба: Тэр үедээ юу, Зүйлийн суварганы хурал л гэдэг байсан.

Жужа: Хэдэн ламтай байсан бэ?

Ч. Жамба: 100-аад ламтай байсан.

Жужа: Хэдэн дугантай байсан бэ?

Ч. Жамба: Аан, дөрвөн дугантай байсан. Цогчин, хайлан, дарь эх, аа нэг нь их нарийн юмаа хийдэг дуган.

Сахиусны дуган.

Жужа: Хийдийн гол шүтээн сахиус юу вэ?

Ч. Жамба: Улаан сахиус, улаан сахиус.

Жужа: Хийд ямар нэртэй газар байсан юм бэ?

Ч. Жамба: Есөн зүйл.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Өдөр тутмын хурал нь?

Ч. Жамба: Цогчин.

Жужа: Энэ хийд хэдэн онд хаагдсан юм бэ?

Ч. Жамба: Та нар сайн мэдэж байгаа. Өнөө бүх юм хаагдахад.

Жужа: Танай хийдэд хутагт хувилгаад байсан уу, ямар ямар хүн байсан бэ?

Ч. Жамба: Удам дагасан хүн бол зөндөө л байсан юм. Хамгийн сүүлчийнх нь яг хаахад Чимэддорж гэж хүн байсан. Наян хэд хүрээд өнгөрсөн. Би сайн мэднэ.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Ч. Жамба: Эргэнэ. Намайг байхад гурав эргэсэн юм. Намар орой л эргэнэ. Майдар анхалж тавиад л ажил нь буруудаад гурван лам баригдаад явсан. Нэг нь бүр алга болсон. Нэг нь 10 жил суугаад гарч ирсэн. Нэг нь удалгүй эргээд ирсэн. Тэр нь тэр Чимэддорж.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Ч. Жамба: Өө хайлан хуралгүй яахав.

Жужа: Хайланд хэдэн лам хурах вэ?

Ч. Жамба: За яг нарийн мэдэхгүй юм. Данстай бүх лам нар л хурдаг байсан байх. Олон лам хүрж байсан.

Жужа: Гавж цолтой хүмүүс байсан уу?

Ч. Жамба: Гавж аа, миний мэдэхийн л ловон багш, тэр хүн л гавж байсан юм.

Жужа: Ганжуур эргэж байсан уу?

Ч. Жамба: Эргэлгүй яахав.

Жужа: Цам бүжиг байсан уу?

Ч. Жамба: Юу гэнэ ээ, дахиад хэл дээ?

Жужа: Цам бүжиг? Шашны цам бүжиг гардаг байсан уу?

Ч. Жамба: Аа цам уу, цам байгаагүй. Цамгүй газар байсан.

Жужа: Хэдэн суварга байсан бэ?

Ч. Жамба: Суварга уу, байсан. Хойд талдаа 3 суварга, гол дундаа нэг суварга ийм 4 суварга байсан.

Жужа: Өндөр гэгээний мэндэлсэн газарт бас суварга байсан уу?

Ч. Жамба: Өө тэгэлгүй яахав. Би сайн мэднэ. Өвгөн суварга гэж сайхан суварга байсан. /Жужа хийдийн дуганууд, суварга, лам нарын хашаа байшинг Ч. Жамба гуайгаар цаасан дээр бүдүүвчлэн зуруулав.

Ч. Жамба: Би өөрийн авга ах ламтайгаа хамт сууж байсан гээд зарим мяндагтан лам нарын сууж байсан хашаа байшинг зураг дээр зааж өгч буй бололтой/

Жужа: Хэдэн жастай байсан бэ?

Ч. Жамба: Нэг л жастай байсан. Суваргын жас гэж хажууханд нь байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

2

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Дуганыг юугаар хийсэн бэ?

Ч. Жамба: Дан шавар, чулуугаар барьсан байсан.

Жужа: Өвгөн суварга хашаатай байсан уу?

Ч. Жамба: Гадуураа шавар хашаатай байсан. Бүр тэгээд дотроо нэг жижиг дугантай. Тэр дуган дотроо суварга нь байдаг байсан юм гэнэ лээ.

Жужа: Богдын хүрээнээс том лам нар ирж байсан уу?

Ч. Жамба: Аа тэрнийг мэдэхгүй, мэдэхгүй.

Жужа: Та хэдэн настайдаа хар болсон бэ?

Ч. Жамба: Би 5 настай суугаад 16 нас хүртлээ шавилсан.Тэгээд л хар болсон.

Жужа: Энэ хийд хэдэн онд хаагдсан бэ?

Ч. Жамба: Үгүй, тэр үймээний үеэр л хаагдсан. Надтай л зэрэг хаагдсан.

Жужа: Одоо тэнд нэг дуган байна? Өндөр гэгээний төрсөн газар хэдэн онд босгосон бэ?

Ч. Жамба: Өө хэдэн онд билээ дээ. 1995, 1996 оны үед юм уу. Аймгийн дарга нар бүгд ирчихээд л наадам хийгээд л сүртэй нээгээд байсан. Тэгэд л тэд ч мартчихсан.Суух лам ч байхгүй, орхигдсон доо хөөрхий.

Жужа: Зүйлийн хурлын өндөр настай лам нар одоо бий юу?

Ч. Жамба: Тэр хуучин хурлын уу, надаас өөр байхгүй ээ. Хоёр байсан юм. Нэг нь ноднин өнгөрсөн. Одоо би л байна. Лам гэхэд хашаа юм. Яг мэдэх юм бол бүгдийг нь мэднэ. Энд тэрний хашаа, тэнд тэрний хашаа гээд л одоо бэлхэн байна.

Жужа: Тэнд ямар нэг тахидаг уул, овоо байсан уу?

Ч. Жамба: Зүүн хайрхан гэж тахидаг уул бий.

Жужа: Та дахиж хэдэн онд лам болсон бэ?

Ч. Жамба: Би юу, би ч өөрийгөө лам л гэж боддог шүү.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3